



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Тариат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас
www.Open.audit.mn
Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор С.Оргил
Утас: 77665858
Цахим хаяг: Info@shinjlenmagadlakhui-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 69
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ш.ЗОЛЗАЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,364,529.6 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,328,181.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 үндсэн зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	291,648,033.59	137,130,594.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	216,827,283.84	36,348,215.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	216,827,283.84	36,348,215.01
3121	Төгрөг	216,827,283.84	36,348,215.01
31211	Төрийн сангийн харилцах	216,827,283.84	36,348,215.01
33	АВЛАГА	-	145,852.67
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	145,852.67
35	БАРАА МАТЕРИАЛ	74,820,749.75	100,636,526.75
351	Түүхий эд материал	29,609,878.00	49,891,096.00
35110	Тусгай зориулалттай материал	29,609,878.00	49,891,096.00
354	Хангамжийн материал	45,210,871.75	50,745,430.75
35410	Бичиг хэргийн материал	2,210,500.00	6,205,900.00
35420	Аж ахуйн материал	40,038,171.75	37,519,171.75
35440	Түлш, шатах тослох материал	-	2,713,500.00
35450	Барилгын засварын материал	2,750,000.00	2,750,000.00
35460	Хүнсний материал	212,200.00	1,556,859.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	765,021,661.41	1,806,924,399.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	765,021,661.41	1,806,924,399.27
392	Биет хөрөнгө	754,503,661.41	1,796,406,399.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	849,778,834.97	1,914,799,389.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	(151,466,995.08)	(185,924,103.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,798,305.00	54,055,787.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,546,007.13)	(17,393,398.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,885,288.94	10,726,768.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,451,638.86)	(2,657,512.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,844,526.00	27,844,526.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,081,405.24)	(6,787,810.50)
39217	Ном	1,742,752.81	1,742,752.81
393	Биет бус хөрөнгө	10,518,000.00	10,518,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,518,000.00	10,518,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,056,669,695.00	1,944,054,993.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,000,000.00
413	Өглөг	-	1,000,000.00
4136	Бусад өглөг	-	1,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,056,669,695.00	1,943,054,993.70
51	Засгийн газрын хувь оролцоо	1,056,669,695.00	1,943,054,993.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	148,749,800.92	148,749,800.92
512	Хуримтлагдсан үр дүн	496,516,922.74	1,382,902,221.44
51210	Өмнөх үеийн үр дүн	496,516,922.74	496,516,922.74
51220	Тайлант үеийн үр дүн	-	886,385,298.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	411,402,971.34	411,402,971.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,056,669,695.00	1,944,054,993.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,363,529,884.94	2,290,014,782.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	244,310,684.94	1,142,417,482.50
120	Нийтлэг татварын бус орлого	244,310,684.94	1,142,417,482.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	244,310,684.94	1,142,417,482.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	244,240,684.94	1,091,138,212.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		51,174,270.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,119,219,200.00	1,147,597,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,036,645,600.00	1,041,301,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,036,645,600.00	1,041,301,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,573,600.00	106,296,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,573,600.00	106,296,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,093,296,946.68	1,403,629,483.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,296,946.68	1,403,629,483.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,076,746,486.68	1,392,187,683.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	722,795,730.95	940,790,479.16
210101	Үндсэн цалин	458,640,855.95	542,822,036.29
210102	Нэмэгдэл	223,576,616.00	317,860,057.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	24,896,678.92
210104	Урамшуулал	40,578,259.00	55,211,706.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,913,853.52	110,077,800.00
210201	Тэтгэврийн даатгал	61,606,274.28	74,859,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,064,846.24	8,807,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,767,030.94	4,405,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,219,854.51	4,405,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,255,847.55	17,599,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,423,600.00	100,582,700.00
210301	Гэрэл, цахилгаан	6,405,008.00	9,627,774.00
210302	Түлш, халаалт	74,536,640.00	86,152,740.00
210303	Цэвэр, бохир ус	1,481,952.00	4,802,186.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	40,370,052.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	23,443,900.00
210408	Бараа материал акталсны зардал	-	16,926,152.00
2105	Нормативт зардал	103,040,950.00	110,934,000.00
210502	Хоол, хүнс	103,040,950.00	110,934,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,250,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	3,250,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	5,230,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,000.00	4,230,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,842,352.21	82,202,652.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,385,150.00	32,967,178.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,621,800.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,835,402.21	49,235,474.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,550,460.00	11,441,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,550,460.00	11,441,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,550,460.00	11,441,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	270,232,938.26	886,385,298.70
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	270,232,938.26	886,385,298.70
---	-------------------------	----------------	----------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,119,289,200.00	1,147,807,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	105,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,119,219,200.00	1,147,702,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,036,645,600.00	1,041,301,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,036,645,600.00	1,041,301,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	105,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,573,600.00	106,296,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,573,600.00	106,296,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,058,335,805.47	1,328,181,368.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,058,335,805.47	1,328,181,368.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,039,946,405.47	1,316,739,568.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	722,308,076.95	940,936,331.83
210101	Үндсэн цалин	458,153,201.95	542,967,888.96
210102	Нэмэгдэл	223,576,616.00	317,860,057.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	24,896,678.92
210104	Урамшуулал	40,578,259.00	55,211,706.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,913,853.52	110,077,800.00
210201	Тэтгэврийн даатгал	61,606,274.28	74,859,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,064,846.24	8,807,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,767,030.94	4,405,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,219,854.51	4,405,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,255,847.55	17,599,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,573,600.00	103,296,200.00
210301	Гэрэл, цахилгаан	6,405,008.00	9,627,774.00
210302	Түлш, халаалт	68,686,640.00	88,866,240.00
210303	Цэвэр, бохир ус	1,481,952.00	4,802,186.00
2105	Нормативт зардал	102,287,875.00	112,278,659.00
210502	Хоол, хүнс	102,287,875.00	112,278,659.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	4,230,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,000.00	4,230,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,383,000.00	42,920,578.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,188,300.00	34,484,678.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,194,700.00	8,435,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,389,400.00	11,441,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,389,400.00	11,441,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,389,400.00	11,441,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	60,953,394.53	(180,374,068.83)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,159,800.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,159,800.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,159,800.00	-
223001	Бусад хөрөнгө	5,159,800.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,159,800.00)	-

Архангай аймгийн Тариат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	55,793,594.53	(180,374,068.83)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		216,827,283.84
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	216,827,283.84	36,348,215.01

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,749,800.92	411,402,971.34	226,283,984.48	786,436,756.74
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,749,800.92	411,402,971.34	226,283,984.48	786,436,756.74
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	270,232,938.26	270,232,938.26
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,749,800.92	411,402,971.34	496,516,922.74	1,056,669,695.00
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	148,749,800.92	411,402,971.34	496,516,922.74	1,056,669,695.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,749,800.92	411,402,971.34	496,516,922.74	1,056,669,695.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	886,385,298.70	886,385,298.70
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,749,800.92	411,402,971.34	1,382,902,221.44	1,943,054,993.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,157,272,900.00	1,147,597,300.00	9,675,600.00	99.16
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,050,976,700.00	1,041,301,100.00	9,675,600.00	99.08
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,050,976,700.00	1,041,301,100.00	9,675,600.00	99.08
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,296,200.00	106,296,200.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	106,296,200.00	106,296,200.00		100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	198,922,000.00	105,000.00	198,817,000.00	0.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	280,000.00	105,000.00	175,000.00	37.5
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	198,642,000.00		198,642,000.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,356,194,900.00	1,147,702,300.00	208,492,600.00	84.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,356,194,900.00	1,328,181,368.83	30,286,531.17	97.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,347,026,100.00	1,316,739,568.83	30,286,531.17	97.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	951,820,200.00	940,936,331.83	10,883,868.17	98.86
210101	Үндсэн цалин	559,371,900.00	542,967,888.96	16,404,011.04	97.07
210102	Нэмэгдэл	342,173,900.00	317,860,057.13	24,313,842.87	92.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт		24,896,678.92	-24,896,678.92	

Архангай аймгийн Тариат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	50,274,400.00	55,211,706.82	-4,937,306.82	109.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,816,400.00	110,077,800.00	7,738,600.00	93.43
210201	Тэтгэврийн даатгал	79,921,800.00	74,859,900.00	5,061,900.00	93.67
210202	Тэтгэмжийн даатгал	9,473,700.00	8,807,500.00	666,200.00	92.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,736,800.00	4,405,400.00	331,400.00	93
210204	Ажилгүйдлийн даатгал	4,736,800.00	4,405,400.00	331,400.00	93
210205	Эрүүл мэндийн даатгал	18,947,300.00	17,599,600.00	1,347,700.00	92.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,296,200.00	103,296,200.00		100
210301	Гэрэл, цахилгаан	10,933,400.00	9,627,774.00	1,305,626.00	88.06
210302	Түлш, халаалт	78,142,800.00	88,866,240.00	-10,723,440.00	113.72
210303	Цэвэр, бохир ус	14,220,000.00	4,802,186.00	9,417,814.00	33.77
2105	Нормативт зардал	121,697,900.00	112,278,659.00	9,419,241.00	92.26
210502	Хоол, хүнс	121,697,900.00	112,278,659.00	9,419,241.00	92.26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00		100
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,660,700.00	4,230,000.00	1,430,700.00	74.73
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,660,700.00	4,230,000.00	1,430,700.00	74.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,734,700.00	42,920,578.00	814,122.00	98.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,935,300.00	34,484,678.00	450,622.00	98.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,799,400.00	8,435,900.00	363,500.00	95.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,441,800.00	11,441,800.00		100
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,441,800.00	11,441,800.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,441,800.00	11,441,800.00		100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,356,194,900.00	1,328,181,368.83	30,286,531.17	97.77
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		216,827,283.84	-216,827,283.84	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		36,348,215.01	-36,348,215.01	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй, залруулаагүй 2,435.8 мянган төгрөгийн зөрчил² илэрч 1 албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 2,435.8 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 15,149.24 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1. Албан шаардлага

3.1.1. Худалдан авалттай холбоотой:

Илрүүлэлт: Тайлант онд 2,435.800 төгрөгийн бараа материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим худалдан авалттай холбоотой	1	2,435.8			1	2,435.8						
Нийт дүн	1	2,435.8			1	2,435.8		-				